

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/45/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Э.Сүнжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24

№

41

танай

-ны №

-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБЯАР

07122088

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	358,198,668.92	998,775,821.86
33	АВЛАГА	0.00	5,000,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	0.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	5,000,000.00
33400	Зээлийн хүүгийн авлага	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	358,198,668.92	993,775,821.86
35100	Түүхий эд материал	317,066,108.84	932,326,048.47
35110	Тусгай зориулалттай материал	0.00	0.00
35130	Эм боох материал	317,066,108.84	932,326,048.47
35400	Хангамжийн материал	41,132,560.08	61,449,773.39
35410	Бичиг хэргийн материал	1,820,850.00	3,908,750.00
35420	Аж ахуйн материал	23,726,860.00	40,792,643.39
35430	Сэлбэг хэрэгсэл	264,650.00	478,380.00
35440	Түлш, шатах тослох материал	15,320,200.08	14,330,000.00
35450	Барилгын засварын материал	0.00	1,940,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,301,351,898.96	1,320,812,186.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,301,351,898.96	1,320,812,186.12
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	1,264,340,298.96	1,284,186,986.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,246,237,980.00	1,246,237,980.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-81,662,513.84	-109,657,376.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,000,000.00	121,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-89,833,333.41	-44,583,333.45
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	160,137,503.32	185,140,067.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	-140,740,852.91	-131,981,974.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,430,717.06	63,291,674.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-51,445,333.42	-48,663,418.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,841,660.00	3,841,660.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-625,527.84	-938,291.76
39300	Биет бус хөрөнгө	37,011,600.00	36,625,200.00
39301	Программ хангамж	2,242,500.00	2,242,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,856,100.00	-2,242,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	36,625,200.00	36,625,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,659,550,567.88	2,319,588,007.98
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,659,550,567.88	2,319,588,007.98
51	Засгийн газрын хувь оролцоо	1,659,550,567.88	2,319,588,007.98
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	896,938,183.90	896,938,183.90
51200	Хуримтлагдсан үр дүн	494,486,814.68	1,155,466,980.28
51210	Өмнөх үеийн үр дүн	315,216,044.56	495,429,540.18
51220	Тайлант үеийн үр дүн	179,270,770.12	660,037,440.10
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	268,125,569.30	267,182,843.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,659,550,567.88	2,319,588,007.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,526,117,959.15	9,222,750,008.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	536,799,119.15	5,584,375,795.38
120	Нийтлэг татварын бус орлого	536,799,119.15	5,584,375,795.38
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	71,680,052.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	536,799,119.15	5,512,695,743.38
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,989,318,840.00	3,638,374,213.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,659,833,200.00	1,989,371,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,659,833,200.00	1,989,371,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	329,485,640.00	1,649,002,513.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	187,734,390.00	277,252,548.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,125,000.00	1,224,845,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	103,626,250.00	146,904,865.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,346,847,189.03	8,562,697,568.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,346,847,189.03	8,562,697,568.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,682,300,680.03	6,133,871,381.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,684,501.40	417,150,303.00
210101	Үндсэн цалин	268,351,000.00	276,369,990.00
210102	Нэмэгдэл	54,859,906.00	64,122,728.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,604,384.00	35,117,385.00
210104	Урамшуулал	41,869,211.40	41,540,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,466,045.00	54,836,707.00
210201	Тэтгэврийн даатгал	36,638,745.00	38,632,707.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,956,800.00	4,051,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,165,500.00	3,240,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	791,400.00	810,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,913,600.00	8,102,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,213,959.00	74,205,088.00
210301	Гэрэл, цахилгаан	6,336,657.00	5,970,242.00
210302	Түлш, халаалт	56,548,384.00	64,135,578.00
210303	Цэвэр, бохир ус	4,328,918.00	4,099,268.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,376,730.92	172,052,052.48

210401	Бичиг хэрэг	4,963,400.00	7,470,700.00
210402	Тээвэр, шатахуун	10,586,059.92	42,161,605.08
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,388,521.00	4,158,660.00
210404	Ном, хэвлэл	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	628,300.00	327,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,810,450.00	117,933,387.40
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	0.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	0.00	0.00
2105	Нормативт зардал	655,401,371.38	4,596,342,283.67
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	654,601,371.38	4,596,142,283.67
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,133,980.00	337,721,946.29
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,573,080.00	330,743,146.29
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,550,950.00	231,000.00
210604	Урсгал засвар	22,009,950.00	6,747,800.00
2107	Томилолт, зочны зардал	6,963,500.00	3,071,500.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	6,963,500.00	3,071,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,970,699.60	42,732,923.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,765,593.60	37,612,771.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	173,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,790.00	600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,448.00	38,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	42,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,054,202.00	3,624,128.00
210807	Газрын төлбөр	188,716.00	180,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	468,950.00	471,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	397,089,892.73	435,758,577.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	331,971,760.00	374,086,212.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,178,500.00	1,882,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,939,632.73	59,789,764.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	664,546,509.00	2,428,826,187.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	644,252,475.00	2,421,042,405.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	332,637,195.00	503,787,400.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	307,830,580.00	793,045,005.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,784,700.00	1,124,210,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,294,034.00	7,783,782.20
213302	Хаагдсан данс	0.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,189,874.00	7,138,716.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	104,160.00	645,066.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	179,270,770.12	660,052,440.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	15,000.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	15,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	179,270,770.12	660,037,440.10
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,989,318,840.00	3,638,374,213.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,989,318,840.00	3,638,374,213.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,659,833,200.00	1,989,371,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,659,833,200.00	1,989,371,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	329,485,640.00	1,649,002,513.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	187,734,390.00	277,252,548.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,125,000.00	1,224,845,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	103,626,250.00	146,904,865.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,976,236,690.00	3,630,789,213.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,976,236,690.00	3,630,789,213.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,311,690,181.00	1,196,963,025.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,684,502.00	417,150,303.00
210101	Үндсэн цалин	268,351,000.00	276,369,990.00
210102	Нэмэгдэл	54,859,906.60	64,122,728.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,604,384.00	35,117,385.00
210104	Урамшуулал	41,869,211.40	41,540,200.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,466,045.00	54,836,707.00
210201	Тэтгэврийн даатгал	36,638,745.00	38,632,707.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,956,800.00	4,051,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,165,500.00	3,240,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	791,400.00	810,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,913,600.00	8,102,000.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,213,959.00	74,205,088.00
210301	Гэрэл, цахилгаан	6,336,657.00	5,970,242.00
210302	Түлш, халаалт	56,548,384.00	64,135,578.00
210303	Цэвэр, бохир ус	4,328,918.00	4,099,268.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,697,373.00	25,969,010.00
210401	Бичиг хэрэг	4,027,002.00	3,461,200.00
210402	Тээвэр, шатахуун	12,163,000.00	12,680,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,388,521.00	4,158,660.00
210404	Ном, хэвлэл	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,029,550.00	3,387,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,089,300.00	2,281,250.00
2105	Нормативт зардал	275,567,375.00	108,382,065.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	274,767,375.00	107,582,065.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,750,800.00	12,225,430.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,003,300.00	1,666,900.00
210604	Урсгал засвар	21,747,500.00	10,558,530.00
2107	Томилолт, зочны зардал	6,963,500.00	3,071,500.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	6,963,500.00	3,071,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,091,547.00	44,913,922.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,365,593.00	37,612,770.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	173,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,790.00	600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,448.00	38,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,860,000.00	5,548,128.00
210807	Газрын төлбөр	188,716.00	180,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,184,000.00	728,300.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	422,255,080.00	456,209,000.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	419,772,180.00	454,326,400.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,482,900.00	1,882,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	664,546,509.00	2,433,826,187.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	644,252,475.00	2,421,042,405.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	332,637,195.00	503,787,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	307,830,580.00	793,045,005.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,784,700.00	1,124,210,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,294,034.00	12,783,782.20
213302	Хаагдсан данс	0.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,189,874.00	7,138,716.00
213304	Хөрөнгийн	0.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	104,160.00	5,645,066.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,082,150.00	7,585,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	13,082,150.00	7,585,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,082,150.00	7,585,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,082,150.00	7,585,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,082,150.00	7,585,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-13,082,150.00	-7,585,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	896,938,183.90	268,221,010.57	315,120,603.29	1,480,279,797.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	95,441.27	95,441.27
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	896,938,183.90	268,221,010.57	315,216,044.56	1,480,375,239.03
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-95,441.27	0.00	-95,441.27
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	179,270,770.12	179,270,770.12

10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	896,938,183.90	268,125,569.30	494,486,814.68	1,659,550,567.88
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	896,938,183.90	268,125,569.30	494,486,814.68	1,659,550,567.88
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	942,725.50	942,725.50
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	896,938,183.90	268,125,569.30	495,429,540.18	1,660,493,293.38
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-942,725.50	0.00	-942,725.50
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	660,037,440.10	660,037,440.10
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	896,938,183.90	267,182,843.80	1,155,466,980.28	2,319,588,007.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,989,371,700.00	1,982,232,984.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,989,371,700.00	1,982,232,984.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690,983,200.00	684,190,579.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,402,400.00	417,150,303.00
210101	Үндсэн цалин	276,934,400.00	276,369,990.00
210102	Нэмэгдэл	64,122,800.00	64,122,728.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,805,000.00	35,117,385.00
210104	Урамшуулал	41,540,200.00	41,540,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,415,700.00	54,836,707.00
210201	Тэтгэврийн даатгал	40,211,700.00	38,632,707.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,051,000.00	4,051,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,240,800.00	3,240,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	810,200.00	810,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,102,000.00	8,102,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,205,100.00	74,205,088.00
210301	Гэрэл, цахилгаан	7,434,300.00	5,970,242.00
210302	Түлш, халаалт	61,970,800.00	64,135,578.00
210303	Цэвэр, бохир ус	4,800,000.00	4,099,268.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,631,600.00	26,251,010.00

210401	Бичиг хэрэг	4,029,000.00	3,461,200.00
210402	Тээвэр, шатахуун	12,163,500.00	12,680,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,260,300.00	4,158,660.00
210404	Ном, хэвлэл	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,478,800.00	3,387,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,700,000.00	2,563,250.00
2105	Нормативт зардал	31,327,000.00	31,306,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,527,000.00	30,506,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,805,500.00	14,558,430.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	2,499,900.00
210604	Урсгал засвар	10,805,500.00	10,558,530.00
2107	Томилолт, зочны зардал	4,980,000.00	2,971,500.00
210702	Дотоод албан томилолт	4,980,000.00	2,971,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,204,400.00	44,913,922.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,988,400.00	37,612,770.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	173,000.00	173,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	176,000.00	38,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,055,000.00	5,548,128.00
210807	Газрын төлбөр	396,000.00	180,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	750,000.00	728,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,011,500.00	17,997,519.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,128,600.00	16,114,919.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,882,900.00	1,882,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,298,388,500.00	1,298,042,405.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,298,388,500.00	1,298,042,405.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	503,787,400.00	503,787,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	793,381,100.00	793,045,005.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,220,000.00	1,210,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,989,371,700.00	1,982,232,984.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,989,371,700.00	1,982,232,984.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,989,371,700.00	1,982,232,984.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,649,002,513.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,649,002,513.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	520,357,446.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-
2105	Нормативт зардал	-	77,075,965.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	77,075,965.00
2107	Томилолт, зочны зардал	-	100,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		100,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	443,181,481.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		443,181,481.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,128,645,066.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,123,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,123,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,645,066.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,645,066.20
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,649,002,513.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,649,002,513.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	277,252,548.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,224,845,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	146,904,865.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 62 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 62 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 1,898.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 39.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 31.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 9,222.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 184.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 147.6 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрүүл мэндийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28.45 хувиар буюу 660.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Өмнө онд авлагын үлдэгдэл байхгүй. Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн 5.0 сая төгрөгийн авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 998.8 сая төгрөг болж 640.6 сая төгрөгөөр өссөн нь товлोलт дархлаажуулалтын вакцин, ковид-19 цар тахлын вакцин, эм эмнэлгийн хамгаалах хэрэгсэл хандив тусламжийн бараа материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 7.5 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 5,512.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 5,124.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 998.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,320.8 сая төгрөг болж 19.46 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 7.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 71.8 сая төгрөгийн вакцины хөргөгч, автомашин, компьютер тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна. Үнэ төлбөргүй хүлээж авсан тавилга хэрэгсэл байхгүй байна. 87.8 сая төгрөгийн хөрөнгийг акталсан ба тайлант оны эцэст 1,320.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Хугацаа дуусаж цаашид ашиглагдах боломжгүй актлагдсан машин тоног төхөөрөмж 16.7 сая төгрөг, тавилга эд хогшил 8.1 сая төгрөг, шилжүүлэн авсан авто тээврийн хэрэгсэл 63.0 сая төгрөг байна.

Өмнө онд болон тайлант хугацаанд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,319.5 сая төгрөг болж 660.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого /үнэ төлбөргүй авсан бараа материал/ өмнөх оноос 940.3 хувиар буюу 5,530.6 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,155.4 сая төгрөг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,996.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 6.7 сая төгрөгөөр бууруулж, 1,989.4 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,989.3 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,989.3 сая төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 1,649.0 сая төгрөг, нийт 5,289.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5,274.6 сая төгрөгийг зарцуулж 12.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,982.3 сая төгрөг буюу 99.9 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 1,649.0 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс хүлээж авсан мөнгөн орлого 277.2 сая төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 146.9 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,224.8 сая төгрөгийн орлогыг тайлагнасан оны эцэст 5.6 сая төгрөгийг татан төвлөрүүлж үүнээс 5.0 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар харуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн орлогыг ЭМС-ын 2021.07.26-ны А/496 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн ажилтанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх шийдвэрийн дагуу нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд, бусад илүү цагийн хөлс олгох, эм эмнэлгийн хэрэгсэл нөөц бүрдүүлэхэд зарцуулах зардлыг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Эрүүл мэндийн газар нь 2021 онд нийт 4,409.9 сая төгрөгийн 133 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 644.3 сая төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 3.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Ур чадварын нэмэгдлийг улирал бүр дүгнэж олгож байх
2. Батлагдсан бүтэц орон тоо

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 72.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 52.6 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 2.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 17.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй болно. Шивэгдээгүй Э баримтыг нөхөн шивүүлж 52.6 сая төгрөгийг залруулсан байна.

4.2 Төлбөрийн акт

Аймгийн хэмжээнд олгосон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг тулгаж үзэхэд 3 хүнд 1.0 сая төгрөгийг дутуу тооцож олгосон, 1 хүнд 0.4 сая төгрөгийг дутуу тооцож олгосон Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5-т "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын, аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Эрүүл мэндийн газарт иргэний өгсөн 0.8 сая төгрөгийн хандивыг нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Аймгийн онцгой комисс, аймгийн Засаг даргад иргэд аж ахуй нэгж байгууллагаас өгсөн хандивыг хөндлөнгийн мэдээллээр тулгаж үзэхэд 1.5 сая төгрөгийн бэлэн мөнгө, 5000 ширхэг маск, орлого аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана" гэсэн нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Эрүүл мэндийн сайдын баталсан байгууллагын чиг үүрэгт байгууллагын орон тоонд батлагдаагүй Нийгмийн эрүүл мэндийн төвийн эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаа хариуцсан мэргэжилтэн гэсэн шинэ орон тоо бий болгож цалинжуулсан нь нь Эрүүл мэндийн сайдын 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А/37 тушаалд өөрчлөлт оруулах тухай хавсралт №1, хавсралт №2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн тайлан, Татварын тодорхойлолт 4.6 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр", нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Э баримтгүй 11.4 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдсөнгүй.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрүүл мэндийн газар	6	72.3		52.6	2	2.1	3	17.6		
5	Дүн	6	72.3		52.6	2	2.1	3	17.6		

/сая төгрөгөөр/